**МОНГОЛ УЛС**
**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 28 өдөр Дугаар А/202 Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 56 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хүүхдийн төлөө зөвлөлөөс зохион байгуулж буй "Ширээний теннисний аварга шалгаруулах тэмцээн"-ийн зардалд 1,352,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 1,352,000 (нэг сая гурван зуун тавин хоёр мянга) төгрөгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний 5.1-д тусгагдсан Боловсролын салбарын төсөл арга хэмжээний зардлаас тооцож гаргахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Батсайхан), Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Б.Гомбосүрэн) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Х.Баасанхүү)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА М.АМАРСАНАА

8400001 0581

Zah A/202 Och

Аймгийн Засаг даргын 2025 оны
03 дугаар сарын 28-ны өдрийн
А/202 дугаар захирамжийн хавсралт

“ШИРЭЭНИЙ ТЕННИСНИЙ АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН”-ИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

| № | Төсөв | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Нэг бүр үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Шагналын зардал (Ахлах анги) | 1-р байр | 1 | 60,000 | 60,000 |
| 2 | | 2-р байр | 1 | 50,000 | 50,000 |
| 3 | | 3-р байр | 1 | 30,000 | 30,000 |
| 4 | Шагналын зардал (Дунд анги) | 1-р байр | 1 | 60.000 | 60,000 |
| 5 | | 2-р байр | 1 | 50,000 | 50,000 |
| 6 | | 3-р байр | 1 | 30,000 | 30,000 |
| 7 | Шагналын зардал (Хосын төрөл) | 1-р байр | 1 | 80,000 | 80,000 |
| 8 | | 2-р байр | 1 | 60,000 | 60,000 |
| 9 | | 3-р байр | 1 | 40,000 | 40,000 |
| 10 | Медаль | ширхэг | 12 | 11,000 | 132,000 |
| 11 | Өргөмжлөл | ширхэг | 14 | 15,000 | 210,000 |
| 12 | Цом | ширхэг | 2 | 100,000 | 200,000 |
| 13 | Шүүгчийн хөлс | хүн | 3 | 50,000 | 150,000 |
| 14 | Мандатын уут | ширхэг | 100 | 2000 | 200,000 |
| Нийт дүн | | | | | 1,352,000 |

-oOo-